

**УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК**

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал  
2017 оны 4 дүгээр сарын 28-ны баасан  
гаригт 10.00 цагт Сүхбаатар дүүрэг  
100 айлын уулзварын баруун хойно  
хэвлэлийн хүрээлэнгийн зүүн талд  
байрлах Барилгын дэвшилтэт технологийн  
төвийн 6 давхрын хурлын танхимд болно.

УЛААНБААТАР ХОТ  
2017 он

**Хувьцаа эзэмшигчдийн 2016 оны ээлжит  
хурлаар хэлэлцэх асуудлууд**

1. Компанийн гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны ажлын тайланг хэлэлцэн батлах
2. Компанийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг батлах
4. Бусад асуудал

-----oOo-----

**ХУРЛЫН ДЭГ**

1.	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	9.20-10.00
2.	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээж үг хэлэх	5 минут
4.	Компанийн 2016 оны үйл ажилллагааны болон санхүүгийн тайлан (Гүйцэтгэх захирал)	15 минут
5.	ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны 2016 оны ажлын тайлан (Хараат бус гишүүн)	15 минут
6.	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөв хэлэлцэх	10 минут
7.	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах	10 минут
8.	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшсэн гишүүдийг танилцуулах	10 минут
9.	Хувьцаа эзэмшигчдээс үг хэлэх, санал гаргах (нэг хүнд)	5 минут
10.	Хэлэлцсэн асуудлаар санал хураах	5 минут
11.	Хурлын завсарлага	20 минут
12.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
13.	Хурлын тогтоолыг танилцуулж, хурлыг хаах (Хурлын дарга)	10 минут

-----oOo-----

## КОМПАНИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ТУЗ-ИЙН ӨГСӨН ДҮГНЭЛТ

### **Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ**

Тайлант хугацаанд “Улсын Их Дэлгүүр” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр Ш.Баярсайхан, А.Шагдарсүрэн, Р.Содном, С.Хосбаяр, Б.Ариунжаргал, А.Норсмаа, ТУЗ-ийн хараат бус гишүүдээр Д.Дашцэдэн, Л.Чулуунбаатар, Н.Батцацрал нар, ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Ж.Мөнхбаатар, компанийн Гүйцэтгэх захирлаар С.Сайнбат, ахлах нягтлан бодогчоор Д.Чимгээ нар ажиллалаа. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн хэтийн төлөв, зорилтыг тодорхойлон хууль дүрэм журамд заасан эрх үүргийн хүрээнд компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, түүний дэргэдэх хороод нь хорооны эрх мэдлийн хүрээнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж Гүйцэтгэх удирдлага нь өдөр тутмын удирдлагаар ханган ажиллаж ирлээ.

**Үйл ажиллагааны талаар:** Компанийн түрээсийн орлогыг нэмэгдүүлэх, өдөр тутмын ашиглалтын зардал, барилгын урсгал засварын зардлуудыг багасган, хэмнэн ажиллахад анхааран ажиллаж байгаагаа Гүйцэтгэх удирдлага ТУЗ-ийн ээлжит хурлуудад байнга танилцуулж байсан. 2016 онд УИД ХК нь 5,400.0 сая төгрөгийн түрээсийн орлого олж, үндсэн үйл ажиллагаанд 4,920.3 сая төгрөгийн зардал гарган, үндсэн үйл ажиллагаанаас 479,7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Компани нь татвараа үнэн зөв тодорхойлж, төлөх тайлагнах үүргээ нэр төртэй биелүүлж нийгмийн хариуцлагаа үлгэр жишээ сахин, эх орныхоо бүтээн байгуулалт хөгжил цэцэглэлтэнд бодитой хувь нэмэр оруулж ирлээ. УИД ХК нь 2016 онд улсын татварт 542,9 сая төгрөгийн татвар төлжээ.

**Барилга засвар болон ашиглалт үйлчилгээний талаар:** УИД-ийн ачааны лифтний хөрсний ус тусгаарлалтын ажил, Дээврийн засварын ажил, Төв хаалгыг шинэчлэн сольж засварласан, 3-р давхарын шалны хэсэгчилсэн засвар, В1 давхар болон 2-7 давхарын хуучин эрчим хүчний зарцуулалт өндөртэй гэрэл гэрэлтүүлгийг орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан, эдийн засгийн хэмнэлттэй, чанар стандартын шаардлага хангасан гэрэл гэрэлтүүлгээр солих ажил, 6-р давхарын заалны талбайг өргөтгөх ажил, 1 ба 4-р давхарын таазыг эмүлсдэж

зассан ажил, 5-р давхарын хойд хэсгийн шалны засвар шинэчлэлтийн болон бусад ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

**Санхүүгийн үйл ажиллагааны талаар:** Тус компани өнгөрсөн онд нийтдээ 5,400. сая төгрөгийн орлого олсон. Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагаанаасаа өнгөрсөн оныхоос 18,1 сая төгрөгөөр илүү буюу 479,7 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Үндсэн бус үйл ажиллагаанаас -1272,1 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, -792,5 сая төгрөгийн алдагдал гарч ААНОАТатварт 49,4 сая төгрөг төлснөөр нийт -841,9 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Алдагдлын 99,94% нь валютын ханшийн зөрүүгийн алдагдал байна.

Тайлант хугацаанд 4920,3 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 374,2 сая төгрөг буюу 7,1 хувиар буурсан бөгөөд үүнээс үйл ажиллагааны зардлын 2089,6 сая төгрөгийг ашиглалт, 163,3 сая төгрөгийг урсгал засвар хийхэд, 1767,8 сая төгрөгийг зээлийн хүүгийн зардалд зарцуулсан байна. Үйл ажиллагааны бус зардал нь ханшийн зөрүүгийн алдагдал буюу -1272,1 сая төгрөг байна. Үйл ажиллагааны зардлыг бүтцээр нь ангилж үзвэл 35,9 хувь буюу 1,767.8 сая төгрөгийг зээлийн хүүгийн зардал, 10.9 хувь буюу 536,5 сая төгрөгийг үндсэн хөрөнгийн элэгдэлийн зардал, 2.7 хувь буюу 132,6 сая төгрөгийг үл хөдлөх хөрөнгө болон газрын татвар, 0,7 хувь буюу 36,1 сая төгрөгийг цалин хөлс НДШ-н зардал, 42,5 хувь буюу 2,089,6 сая төгрөгийг ашиглалттай холбогдолтой зардал болон бусад зардал эзэлж байна .

Өнгөрсөн оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн дүн 9,317,0 сая төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 0,9 хувь буюу 85.6 сая төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 99.1 хувь буюу 9,2314,5 сая төгрөгийг эзэлж байна. Эргэлтийн хөрөнгийн 3,4 хувь буюу 2.9 сая төгрөгийг мөнгө, авлага зэрэг түргэн хөрвөх хөрөнгө, 0,1 хувь буюу 0,1 сая төгрөгийг бараа материал, 96,5 хувь буюу 82,5 сая төгрөгийг урьдчилж төлөгдсөн зардал эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дийлэнх хувь болох 99.6 хувь буюу 13920,6 (хуримтлагдсан элэгдэл нь 4,655,3 сая төгрөг) сая төгрөгийг үндсэн хөрөнгө болох барилга байгууламж, машин тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, 0.4 хувь буюу 33.8 сая төгрөгийг урт хугацаат хөрөнгө оруулалт эзэлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 4,7 хувиар буюу 451,9 сая төгрөгөөр буурсан бөгөөд энэ нь өнгөрсөн онд бий болсон хөрөнгийн элэгдлийн хуримтлалын өсөлттэй холбоотой байна.

Өр төлбөр ба Эзэмшигчдийн өмчийн хувьд бусдад төлөх өр төлбөрийн хэмжээ 10'963,9 сая төгрөг, эзэмшигчдийн өмчийн дүн -1,646,9 сая төгрөг байна. Нийт өр төлбөрийн 99,2 хувь буюу 10876,0 сая төгрөгийг зээл, зээлийн хүүгийн хуримтлагдсан өр эзэлдэг бөгөөд өмнөх оны зээлийн үлдэгдлээс 6.3 хувиар өссөн нь валютын ханшийн өсөлттэй холбоотой. Эзэмшигчдийн өмч оны эхэнд -805.0 сая төгрөг байсан бол оны эцэст -1.646,9 сая төгрөг болж өссөн нь хуримтлагдсан алдагдал өссөнтэй холбоотой байна.

Улсын төвлөрсөн төсвийн ААНОАТатварт 49,4 сая, НӨАТатварт 352.8 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгө болон газрын албан татвар 132.6 сая төгрөг, НДШимтгэл ХХОАТатварт 8,1 сая төгрөг, нийт дүнгээрээ 542.9 сая төгрөгийг төлсөн байна.

Компанийн төлөөлөн удирдах зөвлөөлийн хувьд гүйцэтгэх удирдлагыг Монгол Улсын хуулийн хүрээнд зах зээлийн өнөөгийн байдалд зохицсон үйл ажиллагааг явуулж байна гэж үзэж байна.

## **ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН**

### **Эрхэм хувьцаа эзэмшигчид ээ!**

Тайлант хугацаанд Улсын Их Дэлгүүр ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны гишүүдээр Г.Дашцэрэн, А.Норсмаа, М.Батцацрал нар ажилласан бөгөөд тайлант хугацаанд Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

### **Компанийн санхүүгийн үйл ажиллагааны талаар:**

Тус компани нь 2016 онд нийт 5,400.1 сая төгрөгийн орлого олж, 6,242.0 сая төгрөгийн зардал гарган 841.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант хугацааны орлого өмнөх оноос өөрчлөлтгүй байна.

Тайлант хугацаанд нийт 6,242.0 сая төгрөгийн зардал гарсан ба үүнээс үйл ажиллагааны зардал 4,920,3 сая төгрөг, үйл ажиллагааны бус зардал 1,272.2 сая төгрөг. Үйл ажиллагааны зардлыг ангилж үзвэл 0.7 хувь буюу 36.9 сая төгрөгийн цалин нийгмийн даатгалын шимтгэл, 42.5 хувь буюу 2,089.6 сая төгрөгийн ашиглалтын зардал, 10.9 хувь буюу 536.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдэл, 35.9 хувь буюу 1,767.8 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал, 2.6 хувь буюу 127.6 сая төгрөгийн үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын зардал, 3.3 хувь буюу 163.3 сая төгрөгийн урсгал засварын зардал, 1.4 хувь буюу 67.2 сая төгрөгийн даатгалын зардал, 2.7 хувь буюу 131.4 сая төгрөгийн хөдөлмөр хамгаалал, боловсон хүчин, зар сурталчилгаа, шуудан холбоо, бичиг хэрэг, тээвэр, үйлчилгээ, түрээс, бусад зардал тус тус эзэлж байна.

#### **Авлага, өглөгийн талаар:**

Оны эхэнд дансны авлага 3.5 сая төгрөг оны эцэст 2.8 сая төгрөг болж 0.7 сая төгрөгөөр буюу 20.0 хувиар буурсан байна. Авлагыг ангилж үзвэл худалдан авагчдаас авах авлага 11.3 сая төгрөг, дотоодын бэлтгэн нийлүүлэгчдээс авах авлага 5.0 сая төгрөг, найдваргүй авлагын хасагдуулгын нөөцийн сан -16.7 сая төгрөг, компани хоорондын авлага 2.4 сая төгрөг, бусад авлага 0.8 сая төгрөгийг тус тус эзэлж байна. Авлагын үлдэгдлийг хянахад худалдан авагчаас авах авлага гол хувийг эзэлж байна.

Оны эхэнд 10,671.4 сая төгрөгийн өглөгтэй оны эцэст 10,963.9 сая төгрөг болж 292.5 сая төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Дансны өрийг ангилж үзвэл дотоодын бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өр 0.5 хувь буюу 56.2 сая төгрөг, худалдан авагчдад өгөх өр 0.09 хувь буюу 9.9 сая төгрөг, компани хоорондын өр 0.02 хувь буюу 1.7 сая төгрөг, цалин, бусад татварын өр 0.04 хувь буюу 4.3 сая төгрөг, ногдол ашгийн өр 0.14 хувь буюу 15.4 сая төгрөг, богино хугацаат зээлийн өр 99.21 хувь буюу 10,876.4 сая төгрөг тус тус эзэлж байна.

#### **Үндсэн хөрөнгийн талаар:**

2016 оны эцэст цэвэр дүнгээр 9,197.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй ба тайлант жилд 536.5 сая төгрөгийн элэгдэл байгуулж зардалд тооцсон байна.

### **ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны төсвийн зарцуулалт:**

Өмнөх оны бүх гишүүдийн хурлаар 2016 онд ТУЗ-ийн зардалд 12.1 сая төгрөг төсөвлөсөн ба тайлант хугацаанд 7.3 сая төгрөгийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, хувь нийлүүлэгчдийн хурлын зардал гарсан.

### **Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал:**

Компанийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас батласан “Ажахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт”, “Дансны үлгэрчилсэн заавар”-ын дагуу аккруэл сууриар бэлтгэгдсэн ба энэхүү тайлагналын суурь нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцэж байна.

Компанийн 2016 оны санхүүгийн болон, удирдлагын үйл ажиллагааг санхүүгийн тайлан, анхан шатны баримт, холбогдох бусад баримт, тайлантай тулган хянахад Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэлээ хөтөлж санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харъяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооноос цаашид дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

1. Компани 2017 онд орлого, ашгийг нэмэгдүүлэх, компанийн ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах,
2. Богино хугацаат валютын зээлийн өрийг боломжит хэмжээнд бууруулах,

### **ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо**

**“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2017.04.28-ны өдрийн  
Компанийн хувьцаа эзэмшигчдийн  
ээлжит хурлын саналын хуудас**

Овог нэр: .....

Хувьцааны тоо:..... Регистр № .....

Хурлаар шийдвэрлэх асуудлууд :

1. Компанийн гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах

а. Зөвшөөрсөн                      б. Татгалзсан                      в. Түдгэлзсэн

2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг батлах

а. Зөвшөөрсөн                      б. Татгалзсан                      в. Түдгэлзсэн

3. Компанийн ТУЗ -ийн 2017 оны зардлын төсвийг батлах

а. Зөвшөөрсөн                      б. Татгалзсан                      в. Түдгэлзсэн

**Санамж:**

1. Санал өгөгч нь өгөх саналынхаа өмнөх үсгийг дугуйлна.
2. Саналын хуудсыг балласан, засварласан бол хүчингүйд тооцно.

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг \_\_\_\_\_

2017/04/28

Саналын хуудсыг хүчинтэй/ хүчингүйд тооцсон:

Тооллогын комиссын дарга: \_\_\_\_\_

Гишүүд: \_\_\_\_\_

\_\_\_\_\_



2017 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар  
хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛЫН ТОГТООЛ №01**

Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн  
тайлан, Аудитын хорооны ажлын тайлан,  
2017 оны ТУЗ-ийн төсвийг батлах тухай

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцээд Тооллогын комиссын ... тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн гүйцэтгэх удирдлага болон төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны ажлын тайланг \_\_\_\_\_ гэж үзсүгэй.
2. Компанийн гүйцэтгэх удирдлагын 2016 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагааны талаар төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлтийг \_\_\_\_\_ гэж үзсүгэй.
3. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг хавсралт №01-ээр баталсугай.

**Хурлын дарга**

## ТӨСӨЛ

“Улсын Их Дэлгүүр” ХК-ийн 2017.04.28-ний  
өдрийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн  
хурлын ... тоот тогтоолын хавсралт

### Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны зардлын төсөв

(мянган төгрөгөөр)

1. Гишүүдийн цалин /9 хүн*75,0 мян.төг*12 сар/	8100,0
2. Нарийн бичгийн даргын цалин /75,0 мян.төг*12 сар/	900,0
3. ТУЗ-ийн хурлын зардал	1,000.0
4. Томилолтын зардал	3.000.0
5. Бичиг хэргийн зардал	100.0
6. Унааны зардал	500.0
7. Холбооны зардал /Үүрэн холбооны 75,0 мян.төг*12 сар/	900.0
8. Бусад	600.0
 Дүн	 14,500,0



